

ЗҮҮН ХОЙД АЗИЙН ИНТЕГРАЦИ БА МОНГОЛ УЛС

*А.Буянтөгс**

Зүүн хойд Азийн бүсэд Монгол, Япон, ОХУ, БНХАУ, БНСУ, БНАСАУ мөн Номхон далайн хойд хэсэгт оршдог АНУ, Канад улсууд багтдаг.

Глобалчлал болон бүс нутгийн эдийн засгийн интеграцчлалын явцад Зүүн хойд Ази дахь бүс нутгийн хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж байна. Эдийн засгийн өсөлтөөрөө энэ бүс нутаг нь дэлхийн бусад бүсүүдийг тэргүүлж яваа юм.

Зүүн хойд Азийн бүс нутаг өөрийн нөөц боломжоороо Ази, Номхон далайн бүс нутаг төдийгүй дэлхийн улс төр, эдийн засгийн эрчимтэй хөгжлийн төв болох бүрэн чадалтай.

Зүүн хойд Азийн орнууд бие биенээ харилцан нөхөх шинж чанартай.

Оросын Алс Дорнод нүүрс, байгалийн хий, мод, далайн нөөц, Хятад ХАА-н бүтээгдэхүүн, хямд ажиллах хүч, АНУ, Япон, БНСУ санхүү, технологи болон техник хэрэгслийг нийлүүлэх чадвартай.

Өнөөгийн нөхцөлд аль нэг орон өөрийгөө дэлхийн эдийн засаг, зах зээлээс тусгаарлан бие даан хөгжих боломжгүй болж байна.

Монгол Улсын хувьд ЗХА-ийн бүс нутаг чухал ач холбогдолтой. Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, эдийн засаг, нийгмийн хөгжил нь ЗХА-ийн цаашдын хөгжлөөс ихээхэн хамааралтай болж байгаа юм.

Зүүн хойд Ази нь эдийн засгийн хувьд дэлхийд хамгийн эрчимтэй хөгжиж байгаа бүс нутгийн нэг бөгөөд гадаад зах зээлээс ихээхэн хамааралтай байдгаараа онцлог. Энэ бүс нутаг дахь эдийн засгийн түргэн өсөлтийн гол хүчин зүйлүүдийн нэг нь худалдаа, гадаадын шууд хөрөнгө оруулалт юм.

Зүүн хойд Азийн орнуудтай хийсэн Монголын худалдаа

Монгол Улс өнөөдөр 100 гаруй оронтой худалдаа хийж, нийт худалдааны эргэлт ДНБ-тэй ойролцоо болж байгаагаараа худалдаанаас эдийн засаг нь нэлээд хамааралтай орны тоонд орж байна.

*А.Буянтөгс - ОУСХ-ийн эрдэм ахлах шинжилгээний ажилтан, доктор (Ph.D)

Гадаад худалдааны эргэлт 1990-2005 оны байдлаар (сая ам.доллараар) Хүснэгт №1

Жил	Нийт эргэлт		Экспорт		Импорт	
	Үнийн дүн	Өсөлт, бууралт хувиар	Үнийн дүн	Өсөлт, бууралт хувиар	Үнийн дүн	Өсөлт, бууралт хувиар
1990	1584,7	- 11,2	660,7	- 4,1	924,0	- 15,7
1991	708,9	- 55,3	348,0	- 47,3	360,9	- 60,9
1992	806,7	13,8	388,4	11,6	428,3	15,9
1993	761,7	- 5,6	382,6	- 1,5	379,0	- 9,4
1994	626,0	- 17,8	367,5	- 4,0	258,4	- 31,8
1995	899,3	43,7	511,6	39,2	387,7	50,0
1996	875,2	- 2,7	424,3	- 17,1	450,9	16,3
1997	919,8	- 5,1	451,5	- 6,4	468,3	3,9
1998	789,2	- 14,2	316,8	- 29,8	472,4	0,9
1999	967,0	22,5	454,2	43,4	512,8	8,6
2000	1150,3	19,0	535,8	118,0	614,5	19,8
2001	1159,2	0,8	521,5	- 2,7	637,7	3,8
2002	1214,7	0,1	524,0	- 3,9	690,7	3,3
2003	1387,5	14,2	600,2	14,5	787,3	14,0
2004	1864,9	34,4	853,3	42,2	1011,6	128,5
2005	2200,0	16,5	1053,7	21,2	1148,7	12,5

Эх үүсвэр: Статистикийн ерөнхий газрын мэдээ

2005 оны урьдчилсан гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 2,2 тэрбум ам.доллар, үүнээс экспорт 1053,7 сая ам.доллар, импорт 1148,7 сая ам.доллар болж гадаад худалдааны тэнцэл 95,0 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Гадаад худалдааны алдагдал 2004 оныхоос 37,3 хувь буюу 56,4 сая ам.доллараар буурчээ. Нийт бараа эргэлт 16,5%, экспорт 21,2%, импорт 12,5%-иар тус тус өсөв.

Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 2000-2005 онд (тухайн оны үнээр, сая ам.доллар) Хүснэгт №2

	2000	2001	2002	2003	2004	2005
Нийт эргэлт	1006,5	940,0	1214,7	1387,5	1864,9	2200,0
Экспорт	423,3	385,2	524,0	600,2	853,3	1053,7
Импорт	574,2	554,8	690,7	787,3	1011,6	1148,7
Худалдааны тэнцэл	-141,9	-168,6	-166,7	-187,2	-158,3	-95,0

*Эх үүсвэр: Монголын гадаад худалдааны
тойм (2005 оны байдлаар)*

Хүснэгтээс харахад Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл байнга алдагдалтай явж ирсэн бөгөөд тэр нь нийт эргэлтийн 10 шахам хувьтай тэнцэж байгаа нь эдийн засагт өсөлт гарч, гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаатай холбоотой байна. Харин манай эдийн засаг өсч, дотоодын хуримтлал нэмэгдэхийн хирээр дээрх тэнцлийн алдагдал буурах хандлагатай болно.

Зүүн хойд Азийн орнууд манай гадаад худалдааны 80 орчим хувийг эзэлж байна.

**Монгол Улсын ЗХА-ийн орнуудтай хийж буй
гадаад худалдаа (мян.ам.доллар) Хүснэгт №3**

Он	Худалдаа	БНХАУ	ОХУ	АНУ	Канад	БНСУ	Япон	БНАСАУ
2003	Эргэлт	483288	306606	166477	4465	75124	71925	1633
	Экспорт	287027	41218	142939	711	7472	8509	1075
	Импорт	196260	265387	23538	3753	67652	63416	558
	Хувь	34,1	21,6	11,6	0,3	5,3	5,1	0,02
2004	Эргэлт	632096	362555	202765	20867	70849	108389	1921
	Экспорт	407199	20639	156268	14690	9659	33426	1753
	Импорт	224897	341916	46497	6177	61190	74963	168
	Хувь	33,4	19,2	10,7	1,1	3,7	5,7	0,02
2005	Эргэлт	470958	234615	84211	85144	71740	52720	369
	Экспорт	285604	9855	56647	77220	32380	3089	18
	Импорт	185354	224759	27564	7924	39360	49631	351
	Хувь	37,0	18,4	6,6	6,7	5,6	4,1	0,003

*Эх уусвэр: 2005 оны үзүүлэлт. Оны
эхний 11 сарын байдлаар*

Монгол Улсаас ОХУ-тай хийж байгаа худалдааны эргэлтийн 70 илүү хувь нь Сибирийн бүсэд, мөн Монгол-Хятадын хоёр талын худалдааны эргэлтийн 49,2 хувь, түүний дотор Хятадын нийт импортын 62 хувь нь ӨМӨЗО-д тус тус ногдож байна. Өвөр Монгол нь Монгол Улсын хүнсний хангамжид шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байгаа ба зарим салбарт Өвөр Монголын цөөн томоохон компанийн нийлүүлэлтээс шууд хамаарах болжээ. Тухайлбал, Бугатын “Цао Юань” үйлдвэр манай элсэн чихрийн импортын 90 хувь, Хэ Тао дүүргийн аж ахуйн газрууд гурил, төмсийг үндсэнд нь нийлүүлдэг байна.

Монгол Улсын экспортын бүтэц нь үндсэндээ түүхий эд, эрдэс баялгаас бүрдэж, уул уурхайн бүтээгдэхүүн болох зэсийн баяжмал, алт ихэнх хувийг эзэлж байгаа нь манай орны эдийн засгийн бүтэц урт хугацаанд хөгжлийн хөдөлгүүргүй, экологийн хувьд нийтийн жишгээс өөр чиглэлд хөгжиж байгааг харуулж байна.

Манай орны импортод хамгийн томоохон байр эзэлж буй бүтээгдэхүүн бол түлш шатахуун юм.

Импортын бүтцэд машин, тоног төхөөрөмж, авто машин, сэлбэг хэрэгслийн хувийн жин өндөр байгаа нь сүүлийн жилүүдэд Монголын эдийн засаг сэргэж, гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаатай холбоотой юм.

Монгол дахь Зүүн хойд Азийн орнуудын хөрөнгө оруулалт

Монгол Улсын хүлээн авсан гадаадын хөрөнгө оруулалтын судалгаанаас үзвэл 1990 онд дөнгөж хоёр орон хөрөнгө оруулж байсан бол өнөөдөр манайд дэлхийн 75 орны хөрөнгө оруулалт орж ирээд байна.

Зүүн хойд Азийн орнуудын хөрөнгө оруулалтын эзлэх хувийн жин нь 79,6% болж байна. Үүнд: (2005 оны байдлаар, мян. ам.дол)

Монгол дахь ЗХА-ийн орнуудын хөрөнгө оруулалтын эзлэх хувийн жин Хүснэгт №4

№	Орон	Хөрөнгө оруулалт	Жин
1	Хятад	682,766	47,4
2	Канад	175,736	12,2
3	АНУ	51,217	3,6
4	БНСУ	104,588	7,3
5	Япон	71,346	5,0
6	ОХУ	45,944	3,2

Эх уусвэр: ГШХО-ын тойм, 2005

Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг цаг хугацааны хувьд авч үзвэл түүний 26,44% нь 1990-1999 онд, үлдсэн хэсэг болох 73,55% нь сүүлийн таван жилд ногдож, 500 компани Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулахаар шинээр бүртгүүлсэн байна.

Сүүлийн жилүүдэд манай улсад хөрөнгө оруулагчдын дотор компани, хуулийн этгээдийн эзлэх хувийн жин багасч, хувь хүмүүсийн эзлэх хувь өсөх хандлага ажиглагдаж байна. Энэ нь Монголд гадаадын хөрөнгө оруулалтын хүрээ байнга өргөжин тэлж байгааг нотлон харуулж байна.

Монгол Улсад оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ болон компанийн тоогоороо Зүүн Азийн орнууд дотор БНХАУ тэргүүлж байна. Үүнд:

БНХАУ-ын хөрөнгө оруулагчид:

- Геологи, уул уурхайн судалгаа, эрэл хайгуул, олборлолт - 360 сая ам.доллар;
- Худалдаа, нийтийн хоол – 151 сая ам.доллар;
- Инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл - 29 сая ам.доллар;
- Хөнгөн үйлдвэр – 23 сая ам.доллар;

БНСУ-ын хөрөнгө оруулагчид үйлдвэр, үйлчилгээний салбарыг ихэд сонирхож байна. Өмнөд Солонгосын хөрөнгө оруулалт дараах байдалтай байна. Үүнд:

- Уул уурхайн салбар - 15 сая ам.доллар;
- Хөнгөн үйлдвэр - 6,7 сая ам.доллар;
- Харилцаа, холбоо - 5,7 сая ам.доллар;
- Барилга, барилгын материалын үйлдвэр – 4,6 сая ам.долларын хөрөнгө оруулжээ.

Япон улсын хөрөнгө оруулагчид хөнгөн үйлдвэрийн салбарт хамгийн их хөрөнгө, 28,1 сая ам.долларын хөрөнгө оруулжээ. Тухайлбал:

- Харилцаа холбоо - 8,1 сая ам.доллар.

Нийт хэмжээ 71 сая ам.доллар ба 225 аж ахуйн нэгжтэй. 2005 онд Япон улс нь 5,4 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн байна.

Монгол Улс гадаадын шууд хөрөнгө оруулалтын боломжийн орчин бүрдүүлсний үр дүнд өнөөдөр ОХУ-аас гэхэд л уул уурхайн салбарт 17 сая ам.доллар, барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэлд 5,3 сая ам.доллар, банк санхүүгийн салбарт 4,1 сая ам.доллар, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлд 4,1 сая ам.долларын хөрөнгө оруулалт тус тус хийгдсэн байна.

ОХУ-ын “Алтан Дорнод Монгол” ХХК нь алт олборлолтоороо Монголд тэргүүлж байна.

ГШХО гол салбаруудаар, 2005 онд

№	Салбарын нэр	Мянган ам.доллар
1	Геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолт	191,071
2	Худалдаа, нийтийн хоол	53,930
3	Хөнгөн үйлдвэр	1,840
4	Банк, санхүүгийн үйл ажиллагаа	9,671
5	Барилга, барилгын материалын үйлдвэрлэл	775
6	МАА-н гаралтай түүхий эд боловсруулах	1,125
7	Мэдээлэл, холбооны технологи	6,268
8	Тээвэр	434
9	Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	294
10	Аялал жуулчлал	1,665
11	ХАА, газар тариалан, МАА	2,797
12	Соёл, урлаг, боловсрол, ШУ, хэвлэл	13
13	Мебель, модон эдлэл	22
14	Эрчим хүч	100
15	Эрүүл мэнд, гоо сайхны үйлчилгээ	56
16	Нийтийн ахуйн үйлчилгээ	1,354
17	Цахилгаан хэрэгслийн үйлдвэрлэл	31
18	Гэр ахуйн хэрэгслийн үйлдвэрлэл	194
19	Үнэт зүйлс, бэлэг дурсгал	
20	Бусад	40,119
	ДҮН	311,746

Эх уусвар: ГШХО-ын тойм, 2005

Ийнхүү ГШХО-ын бүтцийг авч үзвэл, Монголд хүлээн авч байгаа ГШХО-ын бараг хагас нь геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолтын салбарт байгаа ба түүний дараа худалдаа, нийтийн хоолны салбар орж байна.

Монголд хүлээн авч байгаа гадаадын шууд хөрөнгө оруулалтын хандлага дэлхийн хандлагатай зарим талаар нийцэхгүй байгаа байдал ажиглагдаж байна. Тухайлбал ЮНКТАД-аас хийсэн судалгаагаар ГШХО-ын ихэнх нь үйлчилгээний салбарт орж байгаа бол манайд энэ салбарын хувь хэмжээ их биш байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт, ялангуяа хамтарсан үйлдвэр компани, аж ахуйн нэгжүүдийн тоо, хэмжээг нэмэгдүүлэх нь экспортлох оюуны багтаамж өндөртэй бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, чанарыг нь олон улсын стандартын шаардлагын түвшинд хүргэх замаар дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадварыг дээшлүүлэх ач холбогдолтой.

Зүүн хойд Азийн интеграци

Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд “Монгол Улсын гадаад бодлогын нэг үндсэн чиглэл бол Азийн бүс нутагт байр сууриа бататгаж, эндэхийн улс төр, эдийн засгийн интеграцид оновчтой оролцох явдал мөн. Энэ зорилтын хүрээнд Ази, Номхон далайн чиглэл, түүний дотор Зүүн хойд Ази, Төв Азийн чиглэлд түлхүү анхаарна. Бүс нутгийн интеграцид орох нөхцлийг юуны өмнө түүнд хамаарч буй улс орнуудтай хоёр талын харилцааг өргөтгөн хөгжүүлэх замаар бүрдүүлнэ” гэж заажээ.

Манай худалдааны гол түнш, хөрөнгө оруулагч, хандивлагчид болох БНХАУ, ОХУ, Япон, БНСУ нь бүгд Зүүн хойд Азийн орнууд юм.

Зүүн хойд Азид бодитойгоор хэрэгжиж эхэлсэн бүс нутгийн хамтын ажиллагаа бол НҮБ-ын XX-ийн ивээл дор боловсрогдсон “Түмэн гол” хөтөлбөр болно.

Түмэн гол төслийн гол онцлог гэвэл Зүүн хойд Азийн бүх орны зангилаа зам дээр оршдогоос гадна бүс нутгийн бүх орныг нэгтгэсэн хоёр төслийн нэг, Зүүн хойд Азийн орнуудын хамтын ажиллагааны механизм болж байгаа юм.

Түмэн гол төслийн үндсэн зорилго нь Зүүн хойд Азийн орнуудын хөгжилд дорвитой нөлөө үзүүлэхүйц дэд бүтэц, худалдаа, үйлдвэр, экологийн зохистой хөгжлийг хамтын чармайлтаар хангах, бүс нутгийн орнуудын эдийн засгийн харилцан бие биеэ нөхөн хөгжих явдлыг дэмжих, ГШХО-ыг татах уур амьсгалыг бий болгох, худалдааны саад

тотторыг арилгах, дамжин өнгөрөх тээврийг хөнгөвчлөхөд оршиж байна. Түмэн голын бүс нутгийг хөгжүүлэхэд нийт 30 тэрбум ам.долларын хөрөнгө хэрэгтэй болох тооцоо гарчээ.

Монгол Улсын хувьд төсөлд эхнээс нь идэвхтэй оролцох байр суурийг баримталж ирсэн ба Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 5 дугаар сарын 24-ний хуралдаанаар Түмэн бүс хөтөлбөрт оролцох асуудлыг авч хэлэлцэн чиглэл гаргаж байжээ. Манай тал Дорнод Монголыг Зүүн хойд Хятадаар дамжуулан Түмэн бүстэй холбох, улмаар түүнийг Түмэн бүсийн нэг төв болгон хөгжүүлэх, ингэхдээ юуны өмнө авто болон төмөр замын сүлжээг бий болгож далайд гарах шинэ гарцыг нээх, ЗХА-ийг хамарсан аялал жуулчлал, байгаль орчны чиглэлээр бүс нутгийн хэмжээнд нэгдсэн төслүүд хэрэгжүүлэхэд түлхүү анхаарах чиглэлийг баримталж байна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. “Монгол Улсын Статистикийн эмхтгэл”. УБ, 2005.
2. “Гадаад худалдааны тойм”. УБ, 2005.
3. “FDI Review 2005”. volume 3.
4. “Зүүн Хойд Ази дахь эдийн засгийн хамтын ажиллагаанд нөлөөлж буй хүчин зүйлс”. УБ, 2002
5. Б.Санжмятав. “Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт”. УБ, 2006.
6. Г.Яскина. “Роль внешнего фактора в политическом и социально-экономическом развитии Монголии”. “Проблемы Дальнего Востока” №3, 2006.